



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Холболтын журам батлах тухай

Монгол Улсын "Эрчим хүчний тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтыг үндэслэн, "ЭБЦТС" ТӨХК, "БЗӨБЦТС" ТӨХК, "ӨБЦТС" ТӨХК, "ДСЦТС" ХК, "Хөвсгөл-Эрчим хүч" ХХК, "Баянхонгор-Эрчим хүч" ХХК, Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгээс ирүүлсэн саналыг хянан хэлэлцээд Эрчим хүчний Зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. "ЭБЦТС" ТӨХК-ийн "Холболтын журам"-ыг нэгдүгээр, "БЗӨБЦТС" ТӨХК-ийн "Холболтын журам"-ыг хоёрдугаар, "ӨБЦТС" ТӨХК-ийн "Холболтын журам"-ыг гуравдугаар, "ДСЦТС" ХК-ийн "Холболтын журам"-ыг дөрөвдүгээр, "Хөвсгөл-Эрчим хүч" ХХК-ийн "Холболтын журам"-ыг тавдугаар, "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-ийн "Холболтын журам"-ыг зургаадугаар, Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн "Холболтын журам"-ыг долоодугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. "Холболтын журам"-ыг мөрдөж ажиллахыг "ЭБЦТС" ТӨХК /Ч.Баттуяа/, "БЗӨБЦТС" ТӨХК /Ш.Доржрагчаа/, "ӨБЦТС" ТӨХК /Ш.Базархүү/, "ДСЦСТ" ХК /С.Нэргүй/, "Хөвсгөл-Эрчим хүч" ХХК /М.Пүрэвсүрэн/, "Баянхонгор-Эрчим хүч" ХХК /М.Батбаяр/, Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг /Г.Сэрээнэндорж/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2002 оны 31 дүгээр тогтоол, 68 дугаар тогтоолын хоёр, гурав, дөрөвдүгээр хавсралт, 2005 оны 54 дүгээр тогтоол, 2006 оны 12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний Зохицуулах хорооны Зохицуулалтын газар /Н.Жигжидсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Р.МЯГМАР

Т.ГАНТӨМӨР

ЭХЗХ-ны 2014 оны 135 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ХОЛБОЛТЫН ЖУРАМ

УХА0315 9128808

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1 “БЗӨБЦТС” ТӨХК-ийн эзэмшлийн цахилгаан түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдийн цахилгаан тоног төхөөрөмж, барилга байгууламж (цаашид “объект” гэх) - ийг холбоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Энэхүү журмын зорилго нь цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох, сүлжээнд холбогдсон хүчин чадлыг нэмэгдүүлэх болон бууруулах талаар иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, объектыг сүлжээнд холбох зэрэг үйл ажиллагаанд цахилгаан түгээх, тусгай зөвшөөрөл эзэмшигч “БЗӨБЦТС” ТӨХК (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч)-ийн хүлээх үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхойлоход оршино.

1.3 Иргэн, хуулийн этгээдийн сүлжээнд шинээр холбогдох, хүчин чадал нэмэгдүүлэх болон бууруулахаар гаргасан хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх үйл явцыг нарийвчлан зохицуулсан журам, заавар, гарын авлагыг тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, нийтэлсэн байна.

Хоёр. Нэр, томьёо

Энэхүү журамд тусгасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1 “**Техникийн нөхцөл**” гэж иргэн, хуулийн этгээдээс шинэ ба шинэчилсэн, өргөтгөсөн объектоо цахилгаан түгээх сүлжээнд холбуулахын тулд заавал хангасан байвал зохих техникийн цогц шаардлагыг;

2.2 “**Санхүүгийн нөхцөл**” гэж цахилгаан түгээх сүлжээний тухайн цэгт объектыг холбохын тулд сүлжээнд хийгдэх өргөтгөл шинэчлэлийн ажлуудын санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ, түүнийг хариуцах нөхцөл болон техникийн нөхцөл олгох үйлчилгээний хөлсийг;

2.3 “**Сүлжээний нөөцийн мэдээлэл**” гэж цахилгаан түгээх сүлжээнд шинээр цахилгаан чадал нэмж холбох боломж, цахилгаан түгээх сүлжээнд хийгдэхээр хөрөнгийн эх үүсвэр нь батлагдсан өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын талаарх мэдээллийг газар зүйн байршил, сум, багаар гаргаж тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нийтэлсэн мэдээллийг;

2.4 “**Үндсэн судалгаа**” гэж цахилгаан түгээх сүлжээнд холбогдох техникийн боломжийг газар дээр нь тодорхойлох, системийн найдваржилт, хүчин чадал, горимын нарийвчилсан тооцоог хийх, шаардлагатай өргөтгөл, шинэчлэлийн ажлуудыг төлөвлөх, холбогдох зардлыг тооцоолох арга хэмжээг;

2.5 “Хэрэглээний горим” гэж цахилгаан түгээх сүлжээнээс хэрэглэх чадлын өөрчлөлтийг сараар болон хоногийн ачааллыг цагаар гаргасан хуваарийг;

**Гурав. Сүлжээнд холбогдох хүсэлт гаргах,
хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх**

- 3.1 Шинэ холболтын хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх үйл явцыг нарийвчлан тайлбарласан заавар, гарын авлагыг хүсэлт гаргагч иргэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн вебсайт-с болон хэрэглэгчдэд үйлчлэх төвд хандаж хэвлэмэл байдлаар авах боломжтой байна.
- 3.2 Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”-ын дагуу 1МВт түүнээс дээш чадал холбох техникийн нөхцлийн хүсэлтийг төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч шийдвэрлэнэ.
- 3.3 Түгээх сүлжээнд энэхүү журмын 3.2-т зааснаас бага чадал холбох техникийн нөхцлийн хүсэлтийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч хүлээн авч шийдвэрлэнэ.
- 3.4 Иргэн, хуулийн этгээд нь цахилгаан түгээх сүлжээний тухайн байршил дээр цахилгаан чадал нэмж холбох хүчин чадал байгаа эсэх лавлагааг сүлжээний нөөцийн мэдээллээс авах боломжийг тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрдүүлсэн байна.
- 3.5 Сүлжээний нөөцийн мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн цахим хуудсанд нийтлэх буюу иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэглэгчдэд үйлчлэх төвд хандан авна.
- 3.6 Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох болон, хүчин чадал нэмэгдүүлэх хүсэлттэй иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахим хуудсаар дамжуулан эсвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэглэгчдэд үйлчлэх төвд өөрийн биеэр ирж иргэн, хуулийн этгээдийн нэр, сүлжээнд холбогдох байршил, хэрэглэх цахилгаан чадал, хэрэглээний горим зэрэг мэдээллийг өгч, бүртгүүлнэ.
- 3.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сүлжээний нөөцийн мэдээлэлд үндэслэн иргэн, хуулийн этгээдийн объектыг сүлжээнд холбох техникийн боломжтой эсэх судалгааг урьдчилсан байдлаар хийж хариуг ажлын 3 хоногт багтаан иргэн, хуулийн этгээдэд өгнө.
- 3.8 Энэхүү журмын 3.7-д заасан урьдчилсан судалгаагаар цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбох боломжтой байршилд хүсэлт гаргасан бол техникийн нөхцөл олгох үндсэн судалгааг хийхэд шаардлагатай мэдээлэл, холбогдох баримт бичгийг ирүүлэх тухай иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.
- 3.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авснаас хойш үндсэн судалгааг 14 хоногийн дотор хийж, шинэ холболтын техникийн болон санхүүгийн нөхцөлийг тусгасан саналыг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд хүргүүлнэ.
- 3.10 Иргэн, хуулийн этгээд нь уг саналыг зөвшөөрч байгаа эсэх тухайгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Энэ хугацаанд мэдэгдээгүй бол уг холболтын санал цуцлагдана.

3.11 Шинэ холболтын саналыг хүлээн зөвшөөрч хариу өгсөн иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөлийг ажлын 3 хоногт багтаан гаргана.

3.12 Цахилгааны өндөр ачаалал бүхий орон сууцны хороолол, томоохон цогцолбор объектод техникийн нөхцөл олгохдоо барилга угсралтын үеийн цахилгаан хэрэглээг хангах түр холболтын нөхцлийг тусгайлан зааж болно.

3.13 Гэрэлтүүлэг, гал тогоо, халаалт зэрэг ахуйн хэрэглээний зориулалтаар 220В-ын хүчдэлийн шугамаар 8 кВт-аас дээш цахилгаан чадал авах болон хэрэглэгчийн цахилгаан хэрэглээний горим, зэрэглэл өөрчлөгдөх тухай бүрт техникийн нөхцөл авна.

3.14 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн шинэ холболтын хүсэлтийг шийдвэрлэсэн байдал, хугацаа, холбох зөвшөөрөл олгосон нийт чадал зэрэг мэдээллийг өөрийн веб сайт-д сар бүр нийтэлнэ.

3.15 Тусгай зөвшөөрөл эзэмшигч техникийн нөхцөл олголтын талаарх мэдээг тогтоосон маягтын дагуу улирал тутам ЭХЗХ-нд хүргүүлнэ.

Дөрөв. Санхүүгийн нөхцөл

4.1 Шинэ холболтын санхүүгийн нөхцөл, түүнийг тооцох аргачлалыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гүйцэтгэх захирлын тушаалаар баталж нийтэд ил тод мэдээлсэн байна.

4.2 Энэхүү журмын 4.1-д заасан аргачлал, түүний дагуу тооцсон холболтын төлбөрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн цахим хуудсаар болон хэрэглэгчдэд үйлчлэх төвөөр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

4.3 Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон техникийн нөхцлийн дагуу хийгдэх шинэ холболтуудын санхүүгийн нөхцлийг журмын 4.1 заалтаар тогтоосон аргачлалын дагуу тооцно.

4.4 Тухайн объектыг цахилгаан түгээх сүлжээнд холбохын тулд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшлийн цахилгаан түгээх сүлжээг өргөтгөхтэй холбоотой зардлын зарим хэсгийг 4.1-д заасан санхүүгийн нөхцөл, аргачлалын дагуу объектоо холбоулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд хариуцаж болно.

4.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр иргэн, хуулийн этгээдийн хүссэн чадлаас их сүлжээний хүчин чадал бий болгох зорилгоор өргөтгөл хийх нөхцөлд энэхүү журмын 4.4-д заасан иргэн, хуулийн этгээдийн хариуцах зардлаас илүү гарсан зардлыг тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

4.6 Объектыг цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбох цахилгааны шугам нь газар доорх инженерийн шугам сүлжээ болон тохижуулсан зам талбай, ногоон байгууламжийг нэвтрэн гарах бол тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг иргэн, хуулийн этгээд хариуцна.

4.7 Объектыг цахилгаан түгээх сүлжээнд холбоход бусад хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд өртөө, хуваарилах байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн хэрэглэгчтэй урьдчилан тохиролцоно.

Тав. Объектыг түгээх сүлжээнд холбох

5.1. Техникийн болон санхүүгийн нөхцөлд тусгасан шаардлагыг бүрэн хангасан объектыг цахилгаан түгээх сүлжээнд холбоно.

5.2. Цахилгаан түгээх сүлжээнд объектоо холбуулах иргэн, хуулийн этгээд нь дор дурьдсан зүйлийг бүрдүүлэн объектыг холбуулахад бэлэн болсон тухайгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид албан ёсоор мэдэгдэнэ. Үүнд:

5.2.1. Цахилгаан түгээх сүлжээ, объектын эзэмшлийн заагийг өмчийн харъяалалаар нарийвчлан тохирсон байх;

5.2.2. Объектын тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэлийн зураг, схем, протокол, хэмжилт, туршилт, тохируулгын актуудыг бүрдүүлсэн байх;

5.3. Объектыг сүлжээнд холбохдоо аюулгүй байдлыг хангах үүднээс хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцсон холболтын хөтөлбөрийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч гүйцэтгэнэ.

5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн объектыг сүлжээнд холбох ажлыг иргэн, хуулийн этгээдийн саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хийж гүйцэтгэнэ. Энэ хугацаанд компанийн техникийн комисс ажиллах ба шинэ хэрэглэгчийн тоолуур, хэмжих хэрэгслийг лацдаж битүүмжлэн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулна.

Зургаа. Хариуцлага

6.1 Техникийн болон санхүүгийн нөхцөлийг үндэслэл муутай эсвэл буруу боловсруулж олгосноос иргэн, хуулийн этгээдэд учирсан шууд хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

6.2 Холболтын журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд "Эрчим хүчний тухай" хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.3 Энэхүү журмын хэрэгжилтэд ЭХЗХ хяналт тавих эрхтэй.

--- оОо ---